

ХЭРХ, ҮЕ ГИШҮҮНИЙ ӨВЧНИЙГ АНАГААХ, ҮЙЛДЭЛТЭЙ ЗАРИМ ЭМИЙН УРГАМЛЫН СУДАЛГАА

Ш.Буяндэлгэр¹, Э.Сансархуяг², Seong-Soo Roh³,
Yoo, Wang-Keun⁴, Ш.Болд⁵

^{1,5}Уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын хүрээлэн

²ЭЗШУИС

^{3,4}Daegu Haany University, Republic of Korea

SOME OF THE MEDICINAL HERBS USED FOR ARTHRITIS IN THE TRADITIONAL MONGOLIAN MEDICINE

Buyandelger Sh¹, Sansarkhuyag E², Seong-Soo Roh³,
Yoo, Wang-Keun⁴, Bold Sh⁵

^{1,5}Traditional Medical Research Institute

²Mongolian University of Pharmaceutical Sciences

^{3,4}Daegu Haany University, Republic of Korea

Abstract

The study of the use of active substances in the raw materials of drugs used in traditional medicine by modern medical methods, especially the relationship between their secondary metabolites and their biological activity, has become a topic of great interest. The purpose of this study is to clarify the taste, potency, and chemical composition of some medicinal herbs used in traditional Mongolian medicine to treat arthritis. The main methods used in the research are *analysis of ancient* source materials and checklist. Four herbs were selected for the study: *Linari buriatica Turcz*, *Veronica incana*, *Inula Britannica*, and *Ledum palustre L*. According to the theory of traditional medicine, the taste, potency and general use of these four herbs are different, but the medicinal herbs have the ability to cure arthritis. In addition, the active substances in the chemical composition of these four herbs has been shown to be effective against a variety of diseases, including: *Linari buriatica Turcz*, used in large doses has purgative action and in small doses, it has the effect of stimulating gastrointestinal peristalsis and secretory function, *Veronica incana* contains cardiac glycosides and saponins while *Inula Britannica* contains inulin, and *Ledum palustre L* have been shown to suppress inflammation and promote apoptosis, or programmed cell death, which is essential for healthy living. However, the use of these four herbs in the treatment of arthritis in traditional medicine is noteworthy and needs to be studied in more depth.

Keywords: medicinal herbs, arthritis, general use, chemical composition

Үндэслэл

Монгол Улс бол өргөн уудам нутаг дэвсгэртэй, байгалийн янз бүрийн баялгаар арвин бөгөөд түүний дотроос ургамлын их нөөцтэй билээ. Ургамлын аймгийн дотор эмийн төрөл бүрийн, ойролцоогоор 900 шахам зүйлийн эмийн ургамал ургаж байна. Эмийн энэхүү нөөцийг Монголын уламжлалт анагаах ухааны эмч, эрдэмтэд нэн эртнээс тухайлбал бидний олж тогтоосон баримтаас үзэхэд Хүннү гүрний үеэс (НТӨ 209-НТ 93 он) эхлэн эм найруулахад ашиглаж байв.

Улмаар 17 дугаар зуунаас эхлэн монгол эмч нар Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны мэдлэгээр оюунаа сэлбэн 800 гаруй төрлийн ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмийн түүхий эдийг хэрэглэж байлаа. Тиймээс уламжлалт анагаах ухаанд хэрэглэж байсан эмийн түүхий эдэд агуулагдах үйлчлэгч бодис, хэрэглээг орчин цагийн анагаах ухааны аргаар судлах, ялангуяа түүнд агуулагдах хоёрдогч метаболитууд тэдний биологийн идэвхийн хоорондын хамаарлын судалгаа ихээхэн сонирхол татсан сэдэв болоод байгаа билээ¹.

Уламжлалт эмийн бэлдмэлийн үйлдэл нь нэг бодисын үйлдэл биш харин түүний найрлага дахь янз бүрийн ургамалд агуулагдаж байгаа биологийн идэвхт нэгдлүүдийн фармакологи үйлдлийн нийлбэр учир тухайн өвчнийг эмчлэхээс гадна биеийн ерөнхий тамир тэнхээг сайжруулдаг, зөөлөн үйлчлэлтэй, шингэц сайтай, хүний биед гаж нөлөө харьцангуй бага байдаг давуу талтай юм.

Судалгааны зорилго

Монголын уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг хэрх, үе гишүүний өвчнийг анагаах үйлдэлтэй зарим эмийн ургамлын амт, чадал, эрдэм болон тэдгээрт агуулагдах химийн бүрэлдэхүүнийг тодруулах.

Судалгааны арга

1. Эх бичиг, сурвалж бичгийн судлал

Судалгаанд авсан эмийн судруудын дотор буй сонгон авсан уламжлалт анагаах ухааны эмийн түүхий эдтэй шууд холбоотой мэдээ, сурвалжуудыг тусгайлан түүвэрлэж жагсаалт хийн задлан шинжилж үр дүнг цагаан толгойн дараалалд оруулан өөр бусад бүтээлүүдийн мэдээллээр баяжуулан дүгнэлт хийлээ.

2. Магадлан жагсаах арга

Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргаар нь сурвалж бичгийг доторх эмийн түүхий эдийг нэгтгэн жагсаан бүрдүүлэх арга юм. Магадлан жагсаах арга нь мэдээллийг төрөлжүүлж ангилахад хялбар, өгөгдөл цуглуулахад хялбар, эхний шатны ажилд үнэлгээ өгөхөд тохиромжтой, төлөвлөсөн нийт ажлыг урьдчилан харах боломжтой, цахим санд оруулахад хялбар байдаг. Тиймээс энэ аргаар эмийн түүхий эдийг тодорхойлсон хэсгийг дэс дараалуулан цахим санд оруулах боломжийг бүрдүүлэв.

Судалгааны үр дүн

Монголын уламжлалт анагаах ухааны ойлголтоор эм гэдэг нь одон зурхайн 5 махбодын шинж чанартай, эмийн 6 амт, 8 чадал, 17 эрдмийн тодорхой хэсгийг агуулсан, өвчнийг анагаан, өвчтөний биед туслах ерөндөг юм. Уламжлалт эмийг онол ёсоор найруулах, эмчилгээний практикт оновчтой хэрэглэхэд эмийн түүхий эдийн тухай гүнзгий мэдлэгийг эмийн амт, хүч, чадал, эрдэм, шингээлт гэсэн суурь ойлголтоор дэлгэрүүлэн тайлбарлаж, уламжлалт эмийн найрлаганд орох эмийн түүхий эдийн онолын үндсийг мэдэх нь нэн чухал байх ёстой байдаг. Бид энэ удаагийн судалгаандаа буриад хонин зажлуур, буурал гандбадраа, британий зоосон цэцэг, намгийн сургар гэсэн дөрвөн ургамлыг сонгон авч амт, чадал, эрдмийг тодруулав.

Судалгаа, шинжилгээ

Ингэхдээ дараах судруудыг гол болгон ашиглалаа.

1. Тойн Жамбалдорж. ᠲᠣᠶᠢᠨᠵᠢᠮᠪᠠᠯᠳᠣᠷᠵᠢ
2. Данзанпунцог. ᠳᠠᠨᠵᠠᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠣᠭ ᠨᠠᠷᠢᠨ бүтээлүүд болно.

Түүнчлэн буриад хонин зажлуур, буурал гандбадраа, британий зоосон цэцэг, намгийн сургарт агуулагдах химийн бүрэлдэхүүнийг энэ чиглэлээр судалгаа хийсэн гадаад, дотоодын зарим судлаачдын судалгааны үр дүнг ашиглав.

Буриад хонин зажлуур



НЭРШИЛ

Монгол нэр: Буриад хонин зажлуур (Буриад зажлуургана)

Латин нэр: *Linaria buriatica* Turcz

Төвөд нэр: ᠪᠦᠷᠢᠠᠳᠠᠬᠣᠨᠢᠨᠵᠠᠵᠢᠯᠠᠭᠤᠷ

Ерөнхий мэдээлэл

30-40 см өндөр, энгийн буюу салаа иштэй, олон наст өвслөг ургамал. Угаараа нарийссан ланцуй буюу шугаман-ланцуй хэлбэрийн бүтэн ирмэгт энгийн навчис ишнээсээ

баруулгүйгээр цувран гарна.

Цайвар шар өнгийн нилээд том хоёр уруулт цэцгүүд ар талдаа урт гээгтэй бөгөөд дээд талын уруул нь хоёр салбант, доод талынх зууван салбантай.

Цэцгүүд нь навчны өврөөс гарсан салааны үзүүрт нэг нэгээрээ байрлах ба ишний үзүүр орчимд бөөгнөрөн цацаг баг үүссгэнэ. Энэ нь нарийхан үндэслэг иштэй.

Тархалт: Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол болон Дундговьд зөвхөн хойд талын сумдын нутагт тохиолдоно. Хээрийн бvсийн уул ба толгодын хажуу, голын эрэг, элс, элсэрхэг хээрт ургана.

Эмэнд хэрэглэх хэсэг: Хортой боловч эмийн тvвхий эд болгон хэрэглэнэ. Навч, цэцэг, ишийг хэрэглэнэ. Түүнийг цэцэглэж буй үед түүж асар, майханд буюу байшингийн төмөр дээвэр доор нимгэн дэлгэж хатаана.

Агуулагдах бодис: Хонин зажлуурын өвсөнд Д-Л пеганин-алкалойд, ферментийн нөлөөллөөр задарч аоцитин ба рутиназа болж хувирдаг Линарин гэдэг флавоны гликозид байдаг. Түүнээс гадна фитостерин, Н-триакатан, аскорбинын хүчил зэрэг бусад бодисууд байдаг нь нотлогджээ.

Пеганин алкалойд холинреактив системийн сэрэхүй чанарыг нэмэгдүүлдэг учраас холинергетик мэдрэлээс сэргэлтийн импульс эрхтэнд дамжуулагдах ажиллагаа идэвхжин улмаар булчингийн хүчдэл нэмэгдэж гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн идэвхждэг болно. Өөрөөр хэлбэл бараг ареколин, пилокарпин, карбохолинтэй төстэй нөлөө үзүүлдэг. Иймээс хонин зажлуурыг их тунгаар хэрэглэхэд туулгах үйлдэл үзүүлнэ. Мөн хонин зажлуурын өвс, түүний экстракт бага тунгаар ходоод гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн, шүүрлийн ажиллагааг идэвхжүүлэх нөлөөлтэй².

Амт, чадал: Гашуун, чадал нь сэрүүн, мохдог, ширүүн³.

Үйлдэл, тус эрдэм: Уламжлалт анагаах ухаанд буриад хонин зажлуурын цэцгийг усан хаван, үе мөч өвдөх, хуян шар ус зэрэг өвчнүүдийг эмчлэхэд дотуур, гадуур хэрэглэж байжээ.

Орос ардын эмнэлэгт түүний навч ишийг туулгах, цөс шээсний ялгаралтыг ихэсгэх, өвдөлтийг намжаах чиглэлээр хэрэглэдэг. Тухайлбал: гэдэсний булчин сулрах, баас хатах, гэдэс дүүрэх, бөөр, элэгний өвчнүүдийг эмчлэхэд элсний мөнх цэцэг, эрдэнэ шишийн багцартай хольж ханд хэлбэрээр хэрэглэдэг. Түүнээс гадна хонин зажлуурын ханд, эсвэл түүний шүүсийг тостой хольж арьсанд түрхэхэд зөөлрүүлэх, үрэвсэл эсэргүүцэх нөлөөлөл үзүүлдэг байна.

Мөн тийм түрхэлгийг экзем, хогжруу, арьсны бусад өвчнүүдийг анагаах зорилгоор түрхнэ. Түүний спиртэн хандны спиртийг ууршуулсны дараа гахайн өөхний тостой хольж арьсны өвчнүүд, шамбарамыг эмчилдэг.

Хонин зажлуурын өвсийг мал эмнэлэгт туулгах, ходоод гэдэсний үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор дотуур бод мал барагцаагаар 15.0-20.0, бог малд 3.0-5.0-аар хэрэглэнэ.

Буурал гандбадраа



НЭРШИЛ

Монгол нэр: Буурал гандбадраа

Латин нэр: *Veronica incana*

Төвөд нэр: གཞུ་ཚོ་དྲ / གན་ཚོ་ཚོ་དྲ

Ерөнхий мэдээлэл

Иршимбийн (Scrophulariaceae) овогт хамаарах 20-50 см өндөр ургадаг олон наст өвслөг ургамал. Цайвар цагаан өнгийн иш, навчистай. Зууван юлдэн хэлбэрийн ишэн дээр эсрэг сууж байрласан навчтай. Ургамлын бүх хэсэг эсгийлэг цагаан үсжилттэй. Цайвар хөх өнгийн сийрэг түрүү хэлбэрийн багцтай.

Тархац: Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Дундад халх, Хянган, Ховд, Дорнод Монгол, Говь-Алтайн тойрогт ойт хээр, хээрийн бүсэд хээрийн нуга шинэсэн ойн захад ургана.

Эмэнд хэрэглэх хэсэг: Газрын дээд хэсгийг хэрэглэнэ.

Агуулагдах бодис: Газрын дээрх хэсэгт апигенин, лютеолин, циноризид оролцсон флавоноид, алкалоид, кофейн болон хлорогенийн хүчлүүд агуулах бөгөөд кумарин, сапонин, иридоид агуулагдана. Зүрхний гликозид илрэх төдий, хөрсөн доорх эрхтэнд сапонин байна⁴. Мөн биологийн идэвхт нэгдэл болох флавоноидууд ихтэй, эдгээр нь бодисын солилцооны ажиллагаанд оролцдог.

Амт, чадал: Исгэлэн, эхүүн амттай, сэрүүн, хөнгөн, мохдог, эелдэг чанартай.

Үйлдэл, тус эрдэм: Хаванг хатаах, өвдөхийг зогсоох, бөөлжихийг зогсоох, шар усыг арилгах чадалтай.

Британий зоосон цэцэг



НЭРШИЛ

Монгол нэр: Британий зоосон цэцэг

Латин нэр: *Inula Britannica*

Төвөд нэр: མ་རྒྱ། མ་བྱལ་གཞེང་རྫོངས

Ерөнхий мэдээлэл

Гол гэсэртэн (Asteraceae) овогт хамаарах 60 см өндөр ургадаг, 2 настай өвслөг ургамал. Гололсон үндэстэй, эгц босоо иштэй, навч нь зууван юлдэн хэлбэртэй цувраа байрласан байх ба цэцэг нь тод шар өнгөтэй бөгөөд ишний оройд ганц нэгээр байрласан сагс хэлбэрийн багцаг үүсгэнэ. Тухайлбал, сагс нь 2-5-аараа нийлж шар өнгийн бамбай баг цэцэг үүсгэнэ. VII сард цэцэглэж, VIII сард үрлэнэ. Гол, нуур, горхийн мараалаг эрэг, булгийн ойролцоох хужиртай нуга, эргийн харгиа, хайрганд ургана.

Тархалт: Монгол орны ургамал газарзүйн Хэнтий, Хангай, Хөвсгөл, Монгол Дагуур, Монгол Алтайн тойрогт том гол горхи, нуурын эрэг дагаж ургана.

Эмэнд хэрэглэх хэсэг: Үндэс.

Агуулагдах бодис: Үндсэнд нь эфирийн тос, лактон, витамин С, инулин, inusterol A, B, C, зэрэг агуулагдана.

Инулин нь хүнсний эслэг (*Dietary fiber*) нэг төрөл юм. Судалгаагаар хоол боловсруулах эрхтний үйл ажиллагааг сайжруулах, чихрийн шижин өвчнийг хянах, жин хасахад тустай. Британий зоосон цэцэгээс ялган авсан sesquiterpene лактон болох эрголид нь RAW 264.7 макрофак дахь цөмийн фактор болох kappaB (NF-kappaB)-ийн экспрессийн nitric oxide synthase (iNOS) болон cyclooxygenase-2 (COX-2)-ийг дарангуйлдаг⁵.

Амт, чадал: Гашуун, давслаг, тэгш, хөнгөн, эелдэг, ширүүн.

Үйлдэл, тус эрдэм: Нян, боом, хавдарыг дарах, хатгалгын эмийн дээд⁶. Халуун боомыг дарах чадалтай. Хатгалгаа дарах, нян хөнөөх, үйлдэлтэй агаад усан хаван, шар усны өвчин, идээ ундаанд дургүй болох, толгой гэмтсэн зэргийг анагаана⁷.

Намгийн сургар



НЭРШИЛ

Монгол нэр: Намгийн сургар

Латин нэр: *Ledum palustre* L

Төвөд нэр: ལུང་དཀར

Ерөнхий мэдээлэл

Сургар нь бор саарал холтос бүхий 50-100 см өндөр иштэй, маш хурц үнэртэй, мөнх ногоон навчит бут юм. 1-6 см урт, 2-15

мм өргөн, гонзгой, навчис нь тун богинохон 2-5 мм бариултай байна. Доошоо эргэсэн захтай зузаавтар илтэстэй эдгээр навчисны дээд тал нь гялалзсан хар ногоон өнгөтэй байхад доод тал нь улбар шар өнгөтэй байна. Сургарын цагаан өнгийн олон тооны цэцэг салаануудын оройд шүхэр маягийн бамбай баг цэцэг үүсгэнэ. Шилбэ нь цэцгээсээ 2-3 дахин урт бөгөөд гадна талаараа шаравтар улаан үсээр бүрхэгдсэн байхаас гадна угтаа хайрсан дагавар навчтай байдаг. Энэ нь удалгүй унана. Дэлбийн өндөг хэлбэртэй мухар хэлтсүүд нь 5-7 мм урт, 3-4 мм өргөн байна. Сургарын цэцэг дэлбээсээ арай урт 10 дохиуртай. Цоморлог нь жижиг дугуй шүдтэй. Түүний дороосоо өөд хагарч нээгддэг 4-7 мм урт, 2.5-4 мм бүдүүн гонзгой бөөрөнхий хэлбэртэй унжуу хонхорцгууд нь цэцгийн тахир шилбэнд бэхлэгдсэн байдаг.

Тархалт: Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур зэрэг мужийн өтгөн ой, намагт ургана.

Эмэнд хэрэглэх хэсэг: Газрын дээд бие, цэцэг

Агуулагдах бодис: Навч, үндэс нь эфирийн тос 0,36-2.5% (хуурай жингийн), танин 1.42-6.73% агуулна⁸. Мөн сургарын камфор, лидол болон чихэр, аргаах эд, салс, арбутин, фитонцид, эриколин зэрэг бодис байдаг. Сүүлийн үеийн судалгаагаар сургар нь үрэвслийг дарах эмийн гол түүхий эд, хавдарын эсийн нэвчдэс (anti-proliferative)-ээс сэргийлэх, хүний эрүүл амьдрахад зайлшгүй шаардлагатай апоптоз буюу эсийн програмчилсан үхлийг дэмждэг болох нь тогтоогджээ⁹.

Амт, чадал: Амт нь амтлаг, гашуун, эхүүн. Чадал нь зөөлөн, хөнгөн, бүлээн.

Үйлдэл, тус эрдэм: Хүйтэн хийг арилгах, дурыг нээх, бадганыг арилгах, биеийг

чийрэгжүүлэх, эс шингэсэн, дуршил хаагдах, хоолой сөөх, уушгины хий хаван, мөгөөрсөн хоолойн удаан чанартай өвчин, халуун хүйтэн харшсан өвчнийг арилгана.

Сургарын хурц үнэр нь хортон шавжийг хөнөөх нөлөөтэй. Гэр, байшин ариутгах, бясаа, жоом, нохой бөөс зэрэг шимэгчид ба хувцас, эд хогшлыг гэмтээгч цагаан эрвээхэй устгахаар голдуу гадуур хэрэглэнэ. Хоол боловсруулах замыг халдваргүй болгох бөгөөд гэдсэн дотор явагдах ялзрах, исэлдэх процессыг багатгана. Түүнчлэн үе мөчний өвчнийг эмчлэхэд хэрэглэдэг. Зарим судлаачдын нотлож байгаагаар булчин ба үе мөчний хэрх өвчтэй хүмүүсийг эмчлэхэд түүний 40 гаруй хувь нь амжилттай эдгэрчээ¹⁰

Дүгнэлт

Бид энэ удаагийн судалгаандаа буриад хонин зажлуур, буурал гандбадраа, британий зоосон цэцэг, намгийн сургар гэсэн дөрвөн ургамлыг сонгон авч амт, чадал, эрдмийг тодруулав. Уламжлалт анагаах ухааны онол ёсоор эдгээр 4 ургамлын амт, чадал, ерөнхий хэрэглээ ялгаатай боловч уг эмийн ургамлуудад хэрх, үе гишүүний өвчнийг анагаах үйлдэл байдаг онцлогтой байна. Түүнчлэн судалгаагаар энэхүү 4 ургамалд агуулагдах химийн бүрэлдэхүүнд янз бүрийн өвчинд үйлчилдэг бодисууд тухайлбал: Буриад хонин зажлуурыг их тунгаар хэрэглэхэд туулгана, бага тунгаар ходоод гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн, шүүрлийн ажиллагааг идэвхжүүлэх нөлөөлтэй, Буурал гандбадраад зүрхний гликозид, сапонин, Британий зоосон цэцэгт инулин, Намгийн сургар нь үрэвслийг дарах эрүүл амьдрахад зайлшгүй шаардлагатай апоптоз буюу эсийн програмчилсан үхлийг дэмждэг үйлдэл байдаг нь тогтоогджээ. Гэхдээ уламжлалт анагаах ухааны хэрэглээнд эдгээр 4 ургамалд

үе мөчний өвчнийг эмчлэх үйлдэл байгаа нь анхаарал татаж, цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.

Ном зүй

1. Э.Сэлэнгэ. Эм зүйн салбар дахь генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн хэрэглээ. *www.mn.undp.org*.
2. Ц.Хайдав. Монгол орны эмийн зарим ургамал. УБ, 1962, х.55-56
3. Данзанпунцог. *བདེ་ནད་གཞོན་པའི་གཞན་པོ་ཚུ་སྐྱེན་གྱི་ནུས་པ་རྒྱང་བཤད་གསལ་སྟོན་དེ་མེད་ཤེས་གོང་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།* модон барын төвөд судар.
4. Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал. Ерөнхий редактор, Академич Ш.Болд. УБ, 2014
5. Jae Kwang Chun, Dong-Wan Seo, Seong Hoon Ahn, Jae Hyun Park, Jueng-Soo You, Chang-Hee Lee, Jae Cheol Lee, Yong Kee Kim, Jeung-Whan Han. Suppression of the NF-kappaB signalling pathway by ergolide, sesquiterpene lactone, in HeLa cells. *J Pharm Pharmacol*. 2007 Apr; 59(4):561-6.

6. Тойн Жамбалдорж. *གསོ་བྱེད་མཛེས་མཚར་མེག་རྒྱན།* модон барын төвөд судар.
7. Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал. Ерөнхий редактор, Академич Ш.Болд. УБ, 2014
8. Монгол орны ашигт ургамлын зурагт лавлах. Намгийн сургар. УБ, 2003, х.107
9. Anna Jesionek, Adam Kokotkiewicz, Anna Mikosik-Roczynska, Klaudia Ciesielska-Figlon, Piotr Luczkiewicz, Adam Bucinski, Agnieszka Daca, Jacek M.Witkowski, Ewa Bryl, Bozena Zabiegala, Maria Luczkiewicz. Chemical variability of *Rhododendron tomentosum (Ledum palustre)* essential oils and their pro-apoptotic effect on lymphocytes and rheumatoid arthritis synoviocytes. *Fitoterapia*, Volume 139, 2019
10. Ц.Хайдав. Монгол орны эмийн зарим ургамал. УБ, 1962, х.40-41

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
 ЭЗУ-ы доктор, дэд профессор
 Л.Уламбаяр